



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 01 сарын 01 өдөр

Дугаар А/37

Өвт

Хорио цээрийн дэглэм бууруулж,
хязгаарлалтын дэглэм тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.12 дэх заалт, Мал, амьтаны эрүүл мэндийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Бат-Өлзий сумын 1, 2 дугаар багийн нутаг дэвсгэрт 2022 оны 03 дугаар сарын 04-ний өдрөөс хойш 28 хоногийн хугацаанд малын гоц халдварт шүлхий өвчний шинж тэмдэг нэмэгдээгүй тул хорио цээрийн дэглэмийг бууруулж хязгаарлалтын дэглэм тогтоосугай.

2. Хязгаарлалтын дэглэмийн үед тэмцэх арга хэмжээ холбогдох заавар зөвлөмжийн дагуу иргэдэд сурталчилах ажлыг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг Мал эмнэлгийн тасгийн даргыг түр орлон гүйцэтгэгч Р.Даваасүрэн, багийн Засаг дарга (Ж.Нямтогтох, Д.Бямбасүрэн, Д.Дэмиддагва) нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

С.АМГАЛАН

